

## **ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ НАМРЫН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

Өргөдлийн байнгын хорооноос 2013 оны ээлжит намрын чуулганы хугацаанд хийж гүйцэтгэсэн ажил нь иргэдийн өргөдөлд судалгаа хийх, хууль тогтоомжийн зөрчилтэй асуудлыг нарийвчлан судлахад чиглэгдсэн. Тус Байнгын хорооны ажлын алба нь хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах талаарх арга хэмжээг судлах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажилласан.

### ***1.Хууль, тогтоолын төслийг хэлэлцүүлэх талаар***

Өргөдлийн байнгын хороо нь Намрын чуулганы хугацаанд нийтдээ 2 удаа 1 цаг 48 минут хуралдав. 2013 оны 11-р сарын 27-ны өдрийн Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар Байнгын хорооны үйл ажиллагааны жилийн тайланг хэлэлцэж, хууль, тогтоолд иргэдээс ирүүлсэн саналын шинжтэй өргөдөл, хуулийн биелэлтэд хяналт тавих талаар ирүүлсэн өргөдлийн судалгаатай танилцсан. Мөн иргэдээс УИХ-ын бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдлийг шийдвэрлэх талаар гишүүдийн ажиллах чиг үүргийн хуваарь, өргөдөл шийдвэрлэх журмыг баталсан.

Иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу Нийгмийн даатгалын тухай хууль болон Цэргийн тэтгэвэр тэтгэмжийн талаарх хууль тогтоомжийн биелэлтийг хангах арга хэмжээ авах, холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар судлан дүгнэлт гаргах үүрэг бүхий хамтарсан Ажлын хэсгийг байгуулсан.

Өргөдлийн байнгын хорооны 2013 оны 12-р сарын 27-ны өдрийн хуралдаанаар Байнгын хороон даргыг сонгох асуудлыг хэлэлцээд УИХ-ын гишүүн Р.Бурмааг улираан сонгохыг санал нэгтэй дэмжсэн.

### ***2. Хяналт шалгалтын ажлын талаар***

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг болон Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн биелэлтийг хангах арга хэмжээ авах, холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар судлан дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан.

Байнгын хорооны ажлын алба Дэд ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, Засгийн газрын тогтоолыг төслийг хүчингүй болгох Улсын Их Хурлын тогтоол батлах талаар Дэд ажлын хэсгийн саналыг боловсруулж, Ажлын хэсгийн ахлагчид танилцуулсан.

Өргөдлийн байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдэд иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу 41 байгууллага албан тушаалтанд өргөдөлд дурдсан асуудлыг шийдвэрлүүлэхээр шилжүүлснээс, хэрэгжилтийг эргэн мэдэгдэх хугацаа, үүрэгтэйгээр 8 албан тоот хүргүүлсэн. Үүний дагуу 3 байгууллагаас иргэдийн өргөдлийн дагуу хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажилласан хариуг иргэд болон Өргөдлийн байнгын хороонд эргэн мэдэгдсэн.

### ***3.Бусад ажлын талаар***

Өргөдлийг цахимаар хүлээн авч хариу өгөх, цахим хэлбэрээр олон нийтийн хэлэлцүүлэг хийх зэрэг дэвшилтэт технологийг ашигласан цахим хуудастай болох ажлын хүрээнд ирэх оны төсөвт 67 сая төгрөг тусгагдаж энэ чиглэлийн туршлага судлах талаар удирдамж боловсруулан ажиллаж байна.

Тус Байнгын хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс “Иргэдийн оролцоотой хууль тогтоох

ажиллагааг дэмжих нь” төслийг албан ёсоор хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэхүү төслийн хүрээнд Байнгын хорооны зарим гишүүд, Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд БНСУ-ын цахим засаглал, Парламентын Байнгын хороод, Авилгын эсрэг болон Иргэний эрхийн комиссын өргөдөл шийдвэрлэлтийн туршлагатай танилцах айлчлалыг зохион байгуулсан.

Цаашид 2014 онд Төрийн байгууллагуудын өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн нэгдсэн программ хангамжийн хэрэгцээ, ажлын хүрээг тодорхойлох, хууль тогтоох ажиллагаанд иргэдийн оролцоог хангах болон Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг боловсронгуй болгоход шаардлагатай судалгааг хийх зэрэг ажлуудыг төслийн хүрээнд төлөвлөж байна.

#### ***4.Байнгын хорооны ажлын албаны гүйцэтгэсэн ажил***

Улсын Их Хурлын дарга, гишүүд, Байнгын хороо, түр, дэд хороодод ирүүлсэн нийт 683 өргөдлийг хүлээн авч бүртгэн, ангиллын дагуу картын бүртгэл хөтөлж, Улсын Их Хурлын ажлын алба болон холбогдох Байнгын хороодод хүлээлгэн өгч, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллав.

Тайлангийн хугацаанд иргэдээс Өргөдлийн байнгын хороонд ирүүлсэн нийт 492 өргөдлийг хугацаанд нь судлан, шийдвэрлэв. Хугацаа хоцорсон өргөдөл байхгүй.

Иргэдээс Улсын Их Хуралд 2013 онд ирүүлсэн өргөдлүүдийг архивын нэгж бэлтгэн архивт хүлээлгэн өгсөн.

Улсын Их Хуралд ирүүлсэн өргөдлийн тайлан, мэдээг сар бүр, эхний хагас жилээр гарган Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлагууд болон Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороодын дарга нарт танилцуулсан.

Өргөдлийн байнгын хорооны үйл ажиллагааг Улсын Их Хурлын цахим хуудас, Байнгын хорооны facebook, twitter хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлан таниулах, мэдээллэх ажлыг тасралтгүй хийсэн.

Иргэдийг мэдээллээр хангах зорилгоор Өргөдлийн байнгын хороонд өргөдөл гаргах зөвлөмж бүхий “Монгол Улсын Өргөдлийн байнгын хороонд өргөдөл гаргах иргэнд зориулсан гарын авлага”-ыг дахин хэвлүүлж, Улсын Их Хурлын гишүүдэд тойрогтоо ажиллахад нь зориулан тараасан.

Мөн Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн 4-р курсын 5 оюутныг Өргөдлийн байнгын хорооны үйл ажиллагаатай танилцуулах, өдөр тутмын ажилд оролцуулах зорилгоор Ажлын албанд 2 сарын хугацаагаар дадлага хийлгэсэн.

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаатай танилцаж, Өргөдлийн байнгын хорооны үйл ажиллагааг орон нутагт сурталчлах, цаашид авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээг тодорхойлох зорилгоор Байнгын хорооны ажлын албаны ажилтнууд Орхон аймагт ажилласан.

Байнгын хорооны ажлын алба Сэлэнгэ аймгийн Мандал сум болон нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Өргөдлийн хороодтой уулзалт зохион байгуулж, Өргөдлийн байнгын хорооны үйл ажиллагааг танилцуулж, цаашид хэрхэн ажиллах талаар эдгээр хороодод санал зөвлөмж өгсөн.